

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРИЛГА

Зарласан өдөр: 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Зөвлөх үйлчилгээний нэр: Төслийн суурь судалгаа хийх

Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр нь Японы Гадаад Харилцааны Яамны санхүүжилтээр “Монгол улсын хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийг нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэг, болон Өвөрхангай, Ховд аймгийн ерөнхий боловсролын 8 сургууль, насан түршийн боловсролын 8 төв дээр хэрэгжүүлнэ.

Төсөл нь зорилтот дүүрэг, аймгийн төрийн өмчийн сургуулиуд болон насан түршийн боловсролын төвд суралцаж буй тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдүүдэд хүртээмжтэй боловсрол олгох зорилготой бөгөөд ерөнхий боловсролын сургуулиудад тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бүрдүүлэх, насан түршийн боловсролын төвд суурилан сурагчдыг сургуульд нь буцаан оруулахад дэмжлэг үзүүлэхийн тулд үндсэн тогтолцоог нь сайн бүрдүүлж, сургуульд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдэд хүрч ажиллах, эдгээр хүчин чармайлтыг олон нийтээр дэмжүүлэхийн тулд эцэг эх, боловсролын ажилтнуудын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, төрийн бодлогод тусгах чиглэлээр ажиллана.

Хүүхдийг Ивээх Сан нь энэхүү төслийн суурь судалгааг хийж гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний багийг сонгон шалгаруулах гэж байгаа тул сонирхсон этгээд техникийн болон үнийн саналаа ирүүлэхийг урьж байна. Зөвлөх үйлчилгээ нь 2018 оны 05 дугаар сарын дундаас эхэлж, 2.5 сарын хугацаанд үргэлжилнэ.

Битүүмжилсэн техникийн болон үнийн саналыг Англи хэл дээр 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 17 цагаас өмнө (Улаанбаатарын цагаар) доорх хаягаар хүлээн авна. Мөн материалыг цахим хаягаар явуулж болно.

Хүлээн авагч: Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Хөтөлбөр
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Аризона төв, 4 давхар,
Утас: 329365, 329371

Цахим хаяг: mongolia.secretary@savethechildren.org;

Дэлгэрэнгүй ажлын даалгавар, бүрдүүлэх бичиг баримтын жагсаалтыг дээрх цахим хаягаар авна уу.